Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,823.8 сая төгрөгөөр буюу 38 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	142.6	36.8	105.8	0.26
Авлага	302.1	360.7	-58.6	1.19
Бараа материал	205.2	68.2	137.0	0.33
Үндсэн хөрөнгө	5523.0	1883.4	3,639.6	0.34
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6172.9</b>	<b>2349.1</b>	<b>3,823.8</b>	<b>0.38</b>
Богино хугацаат өр төлбөр	14.7	12.9	1.8	0.88
Цэвэр хөрөнгө, өмч	6158.2	2336.2	3,822.0	0.38
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6172.9</b>	<b>2349.1</b>	<b>3,823.8</b>	<b>0.38</b>

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, *санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн данснууд байна.*

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 142.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 36.8 сая төгрөг болж 105.8 сая төгрөгөөр буюу 74 хувиар буурсан байна. Энэ нь Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн ерөнхий орлого, ОНХС-ийн орлогыг сумын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн санхүүгийн дэмжлэгт хуваарилсантай холбоотой байна.

#### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 360.8 сая төгрөг болж, өмнөх оноос 58.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.14	-	(0.1)
Төлбөртэй үйлчилгээний авлага	27.9	-	(27.9)
Татаас, санхүүжилтийн авлага	-	0.14	0.14
Байгууллагаас авах авлага	18.60	5.5	(13.1)
Хувь хүмүүсээс авах авлага	52.80	46.8	(6.0)
Урьдчилж гарсан зардал		42.4	42.4
Хувь хүмүүст олгосон зээл	202.7	266.0	63.3
<b>АВЛАГЫН НИЙТ ДҮН</b>	<b>302.1</b>	<b>360.8</b>	<b>58.7</b>

Авлага 58.7 сая төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн буй ЭМТ-ийн авто зогсоол, хашаа шинэчлэх ажил 27.8 сая төгрөг, Наранхайрхан багийн Гулсгайдын худаг гаргах ажилд 14.4 сая төгрөгийн ажлуудыг хүлээн аваагүйтэй холбоотой авлага нэмэгдсэн байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 68.2 сая төгрөг болж 170.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материал дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
<b>Түүхий эд материал</b>	<b>11.2</b>	<b>0</b>	<b>11.2</b>	<b>0.0</b>
Тусгай зориулалттай материал	5.7	0.00	5.7	0.0
Эм боох материал	5.5	0.00	5.5	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	0	0.00	0.0	0.0
<b>Хангамжийн материал</b>	<b>227.3</b>	<b>68.255</b>	<b>159.0</b>	<b>0.3</b>
Бичиг хэргийн материал	9.3	1.10	8.2	0.1
Аж ахуйн материал	136	27.40	108.6	0.2
сэлбэг хэрэгсэл	0	0.00	0.0	0.0
Түлш шатах тослох материал	8.5	5.00	3.5	0.6
Барилгын засварын материал	0.6	0.06	0.5	0.1
Хүнсний материал	28.9	0.00	28.9	0.0
Бусад хангамжийн материал	10.7	1.40	9.3	0.1
Мал амьтан	33.3	33.30	0.0	1.0
<b>Нөөцийн бараа</b>	<b>0</b>	<b>0.00</b>	<b>0.0</b>	<b>1.0</b>
<b>Нийт бараа материал</b>	<b>238.5</b>	<b>68.26</b>	<b>170.2</b>	<b>0.3</b>

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 84.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, аймгаас буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлж, 71.7 сая төгрөгийн материалыг зарцуулж, 68.2 сая төгрөгийн бараа материалын эцсийн үлдэгдэлтэй байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 7025.9 сая төгрөг байсан бол оны эцэст 1883.3 сая төгрөг болж 5142.5 сая төгрөгөөр буурсан нь Засаг даргын тамгын газрын балансад бүртгэлтэй 52.5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, УТ-н байгууллагуудын бүтцийн

өөрчлөлтөөр 4620.2 сая төгрөг хасагдсан мөн 469.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 14.7 сая, эцсийн үлдэгдэл 12.9 сая төгрөг болж 1.8 сая төгрөгөөр буурсан байна. Тайлан хугацаанд орон нутгийн нэмэлт дансаар татан төвлөрүүлсэн 0.14 сая төгрөг, ОНХС-ийн тендерийн гүйцэтгэлийн барьцаа болох 2.9 сая төгрөг, ИТХ-ын 0.03 сая төгрөгөөр тус тус буурсан бөгөөд 10 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжилт авч тэжээл бэлтгэсэн нь, өглөг буураагүйд нөлөөлсөн байна.

### 3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 6172.9 сая төгрөг байснаас оны эцэст 2349.1 сая төгрөг болж 3822.9 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн баланс шилжсэнтэй холбоотой холбоотой байна.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1027.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1027.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 19 өдрийн 4/08 тоот тогтоолоор 1147.2 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны давсан орлоготой холбоотойгоор 2022 онд 1 удаа тодотгол хийн 2022 оны 06 дугаар сарын 27-ны 6/2 тоот тогтоолоор хасаж тодотгон 1041.0 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 6/02 тоот тогтоолоор 1027.1 сая төгрөгөөр баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,027.9 сая төгрөгийн төсөв баталснаас 558.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 321.7 сая төгрөгийг орон нутгийн татварын болон татварын бус орлого орлогоос, 197.0 сая төгрөгийг ОХНС-аас санхүүжих, 6.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 30.2 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, тус тус санхүүжүүлжээ. Аймгийн Засаг даргын А/821 тоот захирамжаар Буянт сумын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн тогтмол зардалд 19.5 сая төгрөгийн төсвийн нэмэлт зохицуулалт хийсэн байна.

*Хүснэгт 5. Нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/сая төгрөгөөр/*

Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Татварын болон татварын бус орлого</b>	341.4	321.7
Татварын орлого	332.7	313.3
Татварын бус орлого	8.7	8.4
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	591.25	558.76
Орон нутгийн төсвөөс	591.2	558.8
Орон нутгийн хөгжлийн сан	197.0	197.0
<b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>	95.25	55.74

Үндсэн үйл ажиллагааны орлогоос	0.6	6.0
Туслах үйл ажиллагааны орлогоос	15.4	49.7
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	79.3	-
<b>ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>1,027.9</b>	<b>936.2</b>

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,003.5 сая төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний зардлын гүйцэтгэл 9.0 сая төгрөг, урсгал шилжүүлэг 5.0 сая төгрөг, хөрөнгийн зардал 43.6 сая төгрөгөөр тус бүр хэмнэж, хоршоо хөгжүүлэх сангийн зээл 33.1 сая төгрөгийн илүү олгосноор, нийт 24.5 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 15.4 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 6.0 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 49.7 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 49.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж 113.1 сая зардал санхүүжүүлэн ажилласан байна.

**Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

/сая төгрөгөөр/

Орлогын ангилал	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	341.4	321.7	19.7
Нийт орлого ба тусламжийн дүн	341.4	321.7	19.7
Татварын орлого	332.7	313.3	19.4
Орлогын албан татвар	197.9	202.6	(4.7)
Хувь хүний орлогын албан татвар	197.9	202.6	(4.23)
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	123.9	132.4	(8.5)
Үйл ажиллагааны орлого	27.2	42.9	(15.7)
Хөрөнгийн орлого	23.0	23.5	
Шууд бус орлого	23.8	3.8	20.0
Хөрөнгийн албан татвар	56.5	44.2	12.3
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2.5	3.5	(1.0)
Бууны албан татвар	1.1	1.1	(0.1)
Малын тоо толгойн албан татвар	53.0	39.6	13.4
Бусад татвар, төлбөр, хураамж	78.3	66.4	11.9
Бусад нийтлэг төлбөр, хураамж	28.5	20.1	8.4
Улсын тэмдэгтийн хураамж	2.5	4.5	(2.0)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	23.0	11.1	11.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3.0	4.5	(1.5)
Газрын төлбөр	25.7	22.7	3.0
Газрын төлбөр	25.7	22.7	3.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	24.1	23.6	0.5
Ан амьтны нөөц ашигласны төлбөр		2.3	(2.3)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	16.1	17.6	(1.6)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	8.0	3.6	4.4
Татварын бус орлого	8.8	8.5	0.3
Торгуулийн орлого	8.2	8.5	(0.3)

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт татварын орлогын гүйцэтгэл 321.7 сая төгрөг биелж 19.7 сая төгрөгөөр тасарсан байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 8.5 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 1.0 сая төгрөг, бууны албан татвар 0.6 сая, ан амьтан нөөц ашигласны төлбөр 2.3 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1.5 сая, үйл ажиллагааны орлого 15.6 сая, хөрөнгийн орлого 0.5 сая, улсын тэмдэгтийн хураамж 2.0 сая, ус, рашаан ашигласны төлбөр 1.6 сая, хүүгийн орлого 0.3 сая төгрөгөөр тус тус орлого давж, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 4.3 сая, малд ногдуулах албан татвар 13.4 сая, шууд бус орлого 20.0 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 11,9 сая, малын тоо толгойн албан татвар 0.9 сая, газрын төлбөр 3.0 сая, төгрөгөөр тус тус тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10 сая төгрөг, Шим –Ус ОНӨААТҮГ-аас 1.3 сая төгрөг, төсвийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 19.5 сая төгрөг, байгаль хамгаалах сангаас 5.0 сая төгрөг, статистикийн хэлтсээс 1.3 сая төгрөг, хамтарсан багийн санхүүгийн дэмжлэг 0.3 сая төгрөг, Зүүн бүсийн шагналд 0.6 сая төгрөг сургууль, цэцэрлэгийн байрны сантехникийн засварын эрх шилжин ирсэн 11.0 сая төгрөг, урьд оны татан төвлөрүүлсэн авлага 0.4 сая төгрөг, аймгийн засаг даргын А/756 тоот захирамжаар иргэдтэй уулзах ажлын хэсгийн зардал 0.2 сая төгрөг, нийт 49.5 сая төгрөгийг төвлөрүүлэн бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд тайлагнан үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор У.Батчимэг 2023 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 03 дугаар сарын 25-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 07-ний өдрийн 1/53 албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,010.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 20.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 80 хувиар буюу 16.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зардал гараагүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, ЗДТГ, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн бөгөөд төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийг мэдээлээгүйг аудитын явцад залруулан цахим системд мэдээлүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар өгөгдсөн 0.2 сая төгрөгийн 2 төлбөрийн акт бүрэн барагдсан 117.5 сая төгрөгийн 3 албан шаардлага, 101.3 сая төгрөгийн 5 зөвлөмж өгөгдсөнийг 87.7 хувиар хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/сая. төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	0.2	2	0.2	-	-	100.0
Албан шаардлага	3	117.5	1	90.5	2	27.0	77.0
Зөвлөмж	5	101.3	5	101.3	-	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>219.0</b>	<b>8</b>	<b>192.0</b>	<b>2</b>	<b>27.0</b>	<b>87.7</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Орон нутгийн хөгжлийн сангийн урьдчилж гарсан зардлаар бүртгэгдсэн ЭМТ-ын хашааны тохижилт, авто зогсоол хийх ажлын 28.0 сая төгрөг, Наранхайрхан багийн Гулсгайн худаг хийх ажлын 14.4 сая, Байгалийн ургамал ашигласны төлбөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн биелэлтэд дахин нарийн горим сорил хэрэгжүүлэн дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 187.7 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрсэн тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Сумын Засаг даргын Тамгын газрын барилгын засвар 187.5 сая төгрөгийг капиталжуулсан бүртгэсэн,
- Үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийг 0.1 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн,
- Хоршоо хөгжүүлэх сангийн 0.1 сая төгрөгийн санхүүгийн программын үнийг зардалд бүртгэсэн

Аудитаар нийт 217.2 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 120.6 сая төгрөгийн 2 албан шаардлага, 94.6 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

- ✓ ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүүхдийн цэцэрлэгийн нэг анги тохижуулах зардалд 5.3 сая төгрөгийг аж ахуй нэгжийн дансанд шилжүүлсэн боловч 1.8 сая төгрөгийн хөрөнгө нийлүүлээгүй, орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

#### 5.2 Албан шаардлага

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### **5.2.1 Хоршоо хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой**

- Хоршоо хөгжүүлэх сангаас 5 аж ахуй нэгж 1 иргэнд 113.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон боловч тухайн зээлийн гэрээнүүдийн зүйл заалт зөрүүтэй, зээлийн гэрээний барьцааны зүйл хүчин төгөлдөр бус, Монгол банкны мэдээллийн сангийн лавлагаа байхгүй, барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувь болон барьцаа хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж барьцаалбар үйлдсэн тухай баримт байхгүй байгаагаас дүгнэхэд удирдлагын зүгээс тавих хяналт сул тухайн зээлүүдийг эргэн төлөгдөхгүй байх эрсдэлд оруулж байгаа зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухайн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах."Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал А/361 тоот тушаалын заалтуудтай тус тус нийцээгүй байна.
- Тайлант хугацаанд байгалийн ургамал ашигласны орлого бодитой тайлагнагдаагүй, татварын орлого бүрдүүлэхэд санаачилга гарган ажиллаагүй бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо нийлж үлдэгдэл баталгаажуулж баримтжуулах ажил зохион байгуулаагүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухайн 23 дугаар зүйлийн 23.8.6-д байгалийн ургамал ашигласны төлбөр; Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5."албан татвар" гэж хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх гэсэн заалттай нийцээгүй.

### **5.3 Зөвлөмж**

#### **5.3.1 Тендерийн бичиг баримттай холбоотой**

**Илрүүлэлт:** Тендерийн баримт бичгийн хуулийн дагуу архив үүсгэж хадгалаагүй, Тендерт шалгарсан болон, шалгараагүй компани мэдээллүүд архивын нэгж үүсгэн хадгалаагүй зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална гэсэн заалтыг хангаагүй.

**Өгсөн зөвлөмж:** Тендерийн баримт бичгийн хуулийн дагуу архив үүсгэн хадгалж хэвших.

#### **5.3.2 Зардлын асуудалтай холбоотой**

**Илрүүлэлт:** ЗДТГ нь овоо тахилга, малчдад тусламж тэтгэмж олгосон, бэлэн мөнгөний кассын тайлан хөтлөөгүй зэрэг нийт 7.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь МУЗГ-ын 43 дугаар тогтоолын 1.6, Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.1, 6.2 дахь заалттай нийцээгүй.

**Өгсөн зөвлөмж:** Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Сумын Засаг даргын Тамгын газрын барилгын засвар 187.5 сая капитлажуулан орлого бүртгэсэн	1	187.5	1	187.5			1	187.5				
Үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийг 0.1 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн,	1	0.1	1	0.1			1	0.1				
Хоршоо хөгжүүлэх сангийн 0.1 сая төгрөгийн санхүүгийн программын үнийг зардалд бүртгэсэн	1	0.1	1	0.1			1	0.1				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>187.7</b>	<b>2</b>	<b>187.7</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>187.7</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүүхдийн цэцэрлэгийн нэг анги тохижуулах зардалд 5.3 сая төгрөгийг аж ахуй нэгжийн дансанд шилжүүлсэн боловч 1.8 сая төгрөгийн хөрөнгө нийлүүлээгүй, орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн зөрчил	1	1.8	1	1.8				
Хоршоо хөгжүүлэх сангаас 5 аж ахуй нэгж 1 иргэнд 113.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон боловч тухайн зээлийн гэрээнүүдийн зүйл заалт зөрүүтэй, зээлийн гэрээний хүчин төгөлдөр бус	1	113.0			1	113.0		
Тайлант хугацаанд байгалийн ургамал ашигласны орлого бодитой тайлагнагдаагүй, татварын орлого бүрдүүлэхэд санаачлага гарган ажлаагүй бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо нийлж үлдэгдэл баталгаажуулж баримтжуулах ажил зохион байгуулаагүй, дотоод хяналт сул	1				1			
ЗДТГ нь овоо тахилга, малчдад тусламж тэтгэмж олгосон, бэлэн мөнгөний кассын тайлан хөтлөөгүй нийт 7.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ.	1	7.6					1	7.6

Тендерийн баримт бичгийн хуулийн дагуу архив үүсгэж хадгалаагүй, Тендерт шалгарсан болон, шалгараагүй компани мэдээллүүд архивын нэгж үүсгэн хадгалаагүй	1							1	
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>122.4</b>	<b>1</b>	<b>1.8</b>	<b>2</b>	<b>113</b>	<b>2</b>	<b>7.6</b>	

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Алдаа зөрчил илэрээгүй		-							
<b>Дүн</b>		-	-	-	-	-	-	-	


**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:**  **Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:**  **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АУДИТОР:**  **У.БАТЧИМЭГ**





ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар Б/А2171039

Ховд

ХОА-2022/03/НА-СТА-ТТЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд аймгийн Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүүхдийн цэцэрлэгийн нэг анги тохижуулах зардалд 5,324.0 мянган төгрөгийг ахуй нэгжийн дансанд шилжүүлсэн боловч 1,824.0 мянган төгрөгийн хөрөнгө нийлүүлээгүй байхад орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн зөрчил зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 202 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээр дурдсан 1824,000 /Нэг сая найман зуун хорин дөрвөн мянган / төгрөгийг Төрийн сан банкин дахь бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 5 дүгээр сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Засаг дарга Б.Түвшинсайхан, санхүү албаны дарга И.Хишигбаяр нарт нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

У.БАТЧИМЭГ

<sup>1</sup> Монгол улс, Ховд аймаг, Цамбагарае баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны сарын 25 өдөр

Дугаар 32/АД/191039

Ховд

ХОА-2022/03/НА-СТА-ТТЗ  
ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар байгалийн ургамал ашигласны татварын орлого ногдуулалтад хадлан эрхлэгч нараас өвс хураан авсан бөгөөд худалдан борлуулж орлого бүрдүүлээгүй, орлого бодитой тайлагнагдаагүй, татварын орлого бүрдүүлэхэд санаачилга гарган ажиллаагүй, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо нийлж үлдэгдэл баталгаажуулж, баримтжуулах ажил зохион байгуулаагүй зөрчил илэрсэн илэрлээ.

Энэ нь Төсвийн тухайн 23 дугаар зүйлийн 23.8.6-д байгалийн ургамал ашигласны төлбөр; Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5."албан татвар" гэж хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгалийн ургамал ашигласны татварын орлого ногдуулалтад хадлан эрхлэгчдээс прессээр тооцон татварын орлого бүрдүүлдэг байдлыг таслан зогсоож хуулийн дагуу нэхэмжлэл үүсгэн орлого бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлэн ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 10-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>3</sup> ирүүлэхийг Б.Түвшинсайхан, Санхүү албаны дарга И.Хишигбаяр нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР

АУДИТОР  У.БАТЧИМЭГ

<sup>3</sup> Монгол улс, Ховд аймаг, Цамбагараа баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас:70433061, 70432545



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 33/АЛН/039

Ховд

ХОА-2022/03/НА-СТА-ТТ3  
ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Хоршоо хөгжүүлэх сангаас 5 аж ахуй нэгж 1 иргэнд 113,000 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон боловч тухайн зээлийн гэрээнүүдийн зүйл заалт зөрүүтэй, зээлийн гэрээний барьцааны зүйл хүчин төгөлдөр бус, Монгол банкны мэдээллийн сангийн лавлагаа байхгүй, барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувь болон барьцаа хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж барьцаалбар үйлдсэн тухай баримт үйлдээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүдээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухайн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах."Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал А/361 тоот тушаалын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зээлийн гэрээг иж бүрэн, үнэн зөв хөтлөн хуулийн хэрэгжилтийг ханган нийт 5 аж ахуй нэгж 1 иргэнтэй холбоотой 113,000 мянган төгрөгийн зээлийн гэрээг шинэчлэн хийж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>2</sup> ирүүлэхийг Б.Түвшинсайхан, нягтлан бодогч Б.Уянга нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БҮЛДБААТАР

АУДИТОР У.БАТЧИМЭГ

<sup>2</sup> Монгол улс, Ховд аймаг, Цамбаагараа баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас:70433061, 70432545